



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/305

Булган сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Б.Энх-Эрдэнэ (ГЭ88081612)-ийн Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 2 дугаар гудамж 200 тоотод байршилтай 6308002486 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 599 м2 газар, Ү.Хишигбаяр (ГЮ57072273)-ын Булган сум 5 дугаар баг Л.Энэбиш 2 дугаар гудамж 229 тоотод байршилтай 6308003685 нэгж талбар бүхий 5-8 давхар нийтийн орон сууц зориулалтаар эзэмшиж буй 2504 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилээр сунгасугай.

2.Б.Энх-Эрдэнэ, Ү.Хишигбаяр нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн Б.Энх-Эрдэнэ, Ү.Хишигбаяр нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АВИУН-ЭРДЭНЭ

